



## ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 5/725

Улаанбаатар хот

### Н.Баяржаргалыг ажлаас чөлөөлж, нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, 82 дугаар зүйлийн 82.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271<sup>1</sup> дүгээр зүйлийн 271<sup>1.1.7</sup>, 271<sup>1.1.10</sup> дахь заалт, Засгийн газрын 2019 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлтээ гаргасан Гаалийн ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын гаалийн улсын байцаагч Норовжавын Баяржаргалыг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Н.Баяржаргалд төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламж болох 12514380 /арван хоёр сая таван зуун арван дөрвөн мянга гурван зуун наян/ төгрөгийг холбогдох журмын дагуу олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.

3. Ажлаас чөлөөлөгдөж байгаа Н.Баяржаргалын гаалийн улсын байцаагчийн хувийн дугаар бүхий тэмдэг, ялгах тэмдгийг хүлээн авахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/, холбогдох тооцоог зохих журмын дагуу хийхийг Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар /Б.Өнөболд/-т тус тус даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ